

**ХАРЬЯАТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ
БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ
ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2025 оны 06 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нараас 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч нь спортын хөгжлийг дэмжих, хүний нөөцийг бэлтгэх, ялангуяа олимпын спортын төрлийг хөгжүүлэх зорилгоор Харьяатын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт олимпын наадмын хөтөлбөрт багтах спортын төрөлд онцгой амжилт гаргасан буюу гаргах боломжтой гадаадын иргэнийг Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын харьяат болгож болох агуулга бүхий нэмэлт оруулах зохицуулалтыг тусгаж хуулийн төслийг боловсруулжээ.

Хууль санаачлагч хуулийн төсөл батлагдсанаар иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад цаг хугацааны, хүний нөөцийн болон мөнгөн зардал үүсэхгүй гэж үзсэн байна.

Уг хуулийн төслийг www.d.parliament.mn цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир гадаадын зарим тамирчид Монгол Улсын нэрийн өмнөөс тэмцээнд оролцож, амжилт гаргах болсонтой холбогдуулан хэчнээн гадаадын тамирчин, тэр дундаа олимпын төрөлд амжилт гаргах боломжтой хүмүүс иргэншил хүссэн эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт "... Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар ил санал хураалт явуулна..." гэж заасны дагуу санал хураалт явуулахад Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт

оруулах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ

Б.ЭНХБАЯР

